


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 11624

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 106 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ГААОНӨГ/202109072 дугаартай Эрдэнэ сумын “Эрчим хүч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нүүрс нийлүүлэх ажлыг “Нэмүүц Алтай” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар (Т.Оргилмаа)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар (Т.Оргилмаа)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газар (Т.Оргилмаа), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ



C:/My documents/-3A-4 doc

0201001864